

ҮҮРЭН ХОЛБОО, ӨРГӨН ЗУРВАСЫН ИНТЕРНЭТИЙН ҮНЭ ТАРИФЫН ХАРЬЦУУЛСАН МЭДЭЭЛЭЛ

ТАНИЛЦУУЛГА


Харилцаа холбооны үйлчилгээ, тэр дундаа өргөн зурвасын интернэт үйлчилгээний хэрэглээ улам бүр өсөн нэмэгдэж, амьдралын өдөр тутмын зайлшгүй хэрэгцээт зүйлийн нэг болсоор байна. Харилцаа холбоо, өргөн зурвасын үйлчилгээ авах боломжит түвшин (affordability), суурь болон хэрэглээний төлбөрийн харьцааг тодорхойлох судалгаа, шинжилгээ хийх, бодлогын чиглэлийг тодорхойлох, үнэлэх зэрэгт үнэ тариф болон үнэ тарифын харьцуулсан мэдээлэл чухал үзүүлэлт болдог.

Олон улсын цахилгаан холбооны байгууллага (ОУЦХБ) нь 2008 оноос үүрэн холбоо, суурин өргөн зурвасын үйлчилгээ, 2012 оноос хөдөлгөөнт өргөн зурвасын үйлчилгээний үнэ тарифын мэдээллийг улс орнуудын харилцаа холбооны яам болон зохицуулах байгууллагуудаар дамжуулан жил бүр авч байна.

ОУЦХБ улс орнуудын харилцаа холбооны үйлчилгээний үнэ тарифыг шинжлэхэд харьцуулалтын арга (benchmarking) ашигладаг бөгөөд үүний тулд үйлчилгээ тус бүрд тодорхой хэмжээний хэрэглээний "сагс" (basket) үүсгэн мэдээллийг цуглуулдаг.

Сагсан дахь яриа, мессеж, дата үйлчилгээний хэмжээ, түүнийг тооцох аргачлалыг ОУЦХБ-ын Экспертүүдийн групп (EGTI)-ийн хурлаар хэлэлцэн үр дүнд шинжилгээ хийж, 2018, 2021 онуудад тус тус нэмэлт өөрчлөлтүүд оруулсан байна.

Дэлгэрэнгүй мэдээлэл, харьцуулсан датаг <https://www.itu.int/itu-d/sites/statistics/> хуудасны ICT prices хэсгээс авах боломжтой. <https://www.itu.int/en/ITU-D/Statistics/Pages/ICTprices/default.aspx>



Зураг 1. ОУЦХБ-ын вэв хуудасны үнийн сагсны мэдээлэл бүхий хэсэг

АРГАЧЛАЛ

ОУЦХБ-аас харилцаа холбооны үйлчилгээний үнэ тарифын судалгааг Зураг 2-т үзүүлсэн **5 сагсны** дагуу цуглуулан авч байна. Сагсны бүтцийг хамгийн сүүлд 2020 онд шинэчилж, 2021 оноос энэ бүтцийн дагуу цуглуулсан.

		Хамгийн бага тогтоосон хэрэглээ:			Үнийн харьцуулалт		
		Яриа (мин)	SMS (тоо)	Дата	USD	\$PPP	%GNI
1	Хөдөлгөөнт өргөн зурвас - Зөвхөн дата	-	-	2 GB			
2	Үүрэн холбоо, Дата, яриа - бага хэрэглээ	70	20	500 MB			
3	Үүрэн холбоо, Дата, яриа - өндөр хэрэглээ	140	70	2GB			
4	Үүрэн холбоо, Яриа - бага хэрэглээ	70	20	-			
5	Суурин өргөн зурвас	-	-	5 GB			

Зураг 2. 2021 оноос мөрдөж буй үнийн сагсны бүтэц

Сагсны аргаар үнийг харьцуулахдаа 3 төрлийн хэмжих нэгж ашигладаг. Үүнд:

1. **USD буюу Америк доллар** - Дэлхийд хамгийн түгээмэл хэрэглэгддэг мөнгөний нэгж, гэхдээ ханшийн зөрүүнд зохиомол гажуудлууд байх магадлалтай.
2. **PPP\$** - Худалдан авах чадварын паритет – Худалдан авах чадварын зөрүүг тохируулсан дүн [1-жилийн хоцрогдолтой]
3. **As a % of monthly GNI per capita - Нэг хүнд ногдох сарын үндэсний нийт орлогын (ҮНО) хувиар** - дундаж орлоготой хүний зардлыг харуулна. (хоцрогдолтой)

Худалдан авах чадварын паритет (PPP – Purchasing Power Parity) нь улс орнуудын үнийн түвшний ялгааг арилгах замаар өөр өөр валютын худалдан авах чадварыг тэнцүүлэхийг оролддог валют хөрвүүлэх ханш юм. (Data.oecd.org)


Худалдан авах чадвар нь бараа, үйлчилгээний харьцуулсан үнэ бөгөөд А улсын мөнгөн тэмдэгтийн 1 нэгжээр А улсад худалдан авах боломжтой адил тооны бараа, үйлчилгээг Б улсад, Б улсын мөнгөн тэмдэгтээр худалдан авах харьцааг илтгэнэ. (ҮСХ, нэр томъёоны тайлбар, <https://metadata.1212.mn/glossarylist.aspx>)

ОУЦХБ-ын ашиглаж буй хэрэглээний сагсны энэ арга нь нэг хэрэглэгчийн нэг сарын дундаж хэрэглээг илэрхийлэх яриа, sms болон датаны тодорхой хэрэглээнд суурилдаг. Үйлчилгээний бүх багцууд, түүний үнэ тарифын мэдээллийг цуглуулж, харьцуулж болох ч энэ нь зардал, нөөц ихээхэн шаардах юм.

Хэрэглээний сагсны аргаар мэдээлэл цуглуулахад ОУЦХБ дараах дүрмийг баримталдаг.

1. Хэрэглэгчийн тоогоор тухайн зах зээлд хамгийн өндөр хувь эзэлж буй үйлчилгээ эрхлэгчийг сонгоно.
2. Тухайн үйлчилгээ эрхлэгчийн үзүүлж буй үйлчилгээний багцуудаас хэрэглээний сагсанд заасан яриа, SMS, дата хэрэглээний хэмжээнд хамгийн ойр тохирох

хамгийн хямд багцыг сонгож авна. Ингэхдээ нэг сараас багагүй хугацааны нөхцөлтэй байх ёстой. Хэрэв үйлчилгээний багцын бүтэц нь хэрэглээний сагсанд заасан хэмжээнээс бага бол сагсанд заасан хэрэглээг гүйцээж, боломжит багц эсхүл үйлчилгээний задгай нэгжээр тооцох хувилбаруудаас хамгийн хямд нөхцөлтэйг сонгож, нэмнэ.



Зураг 3. Хэрэглээний сагсанд тохирох үйлчилгээний багцыг сонгох аргачлал


Дата мэдээллийн чанар ба баталгаажуулалт:

- Үйлчилгээ эрхлэгчдийн үйлчилгээний үнэ тариф болон холбогдох мета өгөгдлийг тухайн улсын зохицуулагчид эсхүл яамдаар дамжуулан 5-6-р сард цуглуулж, ОУЦХБ, А4АI экспертүүд боловсруулдаг.
- ОУЦХБ-аас өгөгдөл, мэдээллийг дээрх байгууллагуудын албан ёсны төлөөлөгч болон мэргэжилтнүүдтэй зөвлөлдөж баталгаажуулдаг.

Монгол Улсын хувьд үүрэн холбоо, өргөн зурвасын интернэтийн үнэ тарифын мэдээллийг дээр дурдсан сагсны аргачлалын дагуу Харилцаа холбооны зохицуулах хорооноос жил бүр гарган хүргүүлж байна.

ҮНЭ ТАРИФЫН ХАРЬЦУУЛАЛТ

Монгол Улсын үүрэн холбоо болон өргөн зурвасын интернэтийн нэг сарын хэрэглээний дундаж үнэ тариф жил ирэх тутам буурч байгааг Зураг 4-өөс харж болно. "Хөдөлгөөнт өргөн зурвас- зөвхөн дата" сагсны хувьд 2018 онд үнэ тариф өссөн нь сагсны үзүүлэлт 2012-2017 он хүртэл 1G, харин 2018-2020 он хүртэл 1.5G болж өөрчлөгдсөнтэй холбоотой байна. 2020 он хүртэл 1G, 1.5G хооронд хэрэглээний ялгаа өндөр байсан бол 2020 оноос хойш сагсны үзүүлэлт 2G болж өөрчлөгдөхөд үнийн өсөлт ажиглагдахгүй байгаа нь нэгж датаны үнэ буурсныг илтгэж байна.



Зураг 4. ОУЦХБ-ын тодорхойлсон 5 сагс тус бүрийн хувьд Монгол Улсын Үүрэн холбоо, хөдөлгөөнт болон суурин өргөн зурвасын интернэтийн үнэ тариф (2013-2021 он), **ам.доллараар**

Дараах хүснэгтэд сагсны бүрэлдэхүүнд орсон өөрчлөлтийг оноор харуулав.

Хүснэгт 1. ОУЦХБ-ын үнийн сагсны бүрэлдэхүүний өөрчлөлт

№	Сагсны нэр	Сагсны бүрэлдэхүүн	Он
1	Суурин өргөн зурвас	1G 5G	2008-2017 2018-
2	Хөдөлгөөнт өргөн зурвас, зөвхөн дата	1G 1.5G 2G	2012-2017 2018-2020 2021-
3	Үүрэн холбоо, яриа - бага хэрэглээ	30мин+100sms 70мин+20sms	2008-2017 2018-
4	Үүрэн холбоо, дата яриа - бага хэрэглээ	70мин+20sms+500MB 70мин+20sms+500MB	2018-2020 2021-
5	Үүрэн холбоо, дата яриа - өндөр хэрэглээ	140мин+70sms+1.5GB 140мин+70sms+2GB	2018-2020 2021-


ОУЦХБ-аас дэлхийн улс орнуудыг бүс нутгаар болон орлогын түвшнээр ангилан дата өгөгдлийн медиан дунджийг авч, бүлгээр нь харьцуулсан мэдээллийг гаргадаг. Улс орнуудыг орлогын түвшнээр ангилахдаа Нэгдсэн Үндэстний Байгууллага болон Дэлхийн банкны ангиллыг ашигладаг бөгөөд Монгол Улсын хувьд Ази Номхон далайн бүс нутаг, Бага дунд орлоготой улсууд болон Далайд гарцгүй хөгжиж буй орнууд гэсэн ангиллуудад хамаардаг.

2021 оны байдлаар Монгол Улсын суурин өргөн зурвасын интернэт (сагс 1) болон үүрэн холбооны ярианы (бага хэрэглээ, сагс 3) үнэ тарифыг дэлхийн дундажтай харьцуулахад ам. доллараар бол 4.3 болон 3.8 дахин бага, PPP буюу худалдан авах чадварын паритет нэгжийн хувьд 2.7 болон 2.4 дахин бага, сарын нэг хүнд ногдох үндэсний нийт орлогод эзлэх


хувиар харьцуулбал 1.6 дахин бага үнэтэй байна. Харин хөдөлгөөнт өргөн зурвас (сагс 2), үүрэн холбооны дата ба ярианы үйлчилгээний (сагс 4, 5) хувьд дэлхийн дундажтай харьцуулахад ам. доллар нэгжээр бол 1.5-1.7 дахин бага, бага дунд орлоготой болон далайд гарцгүй хөгжиж буй улсуудтай ойролцоо, PPP буюу худалдан авах чадварын паритет нэгжийн хувьд дэлхийн дундажтай ойролцоо, харин сарын нэг хүнд ногдох үндэсний нийт орлогод эзлэх хувиар авч үзвэл дэлхийн дунджаас бага зэрэг өндөр байна. (зураг 5, 6, 7)

ОУЦХБ болон Нэгдсэн үндэстний байгууллагын боловсрол, шинжлэх ухаан, соёлын салбар (UNESCO) хамтарч 2010 онд олон улсын бодлогын хөтөлбөрт өргөн зурвасын ач холбогдлыг нэмэгдүүлж, улс орон бүрт өргөн зурвасын хүртээмжийг өргөжүүлэх зорилгоор **“ӨРГӨН ЗУРВАСЫН ХОРОО” (BROADBAND COMMISSION)** -г байгуулсан. Тус хороо нь одоогоор улс орнуудын бизнесийн топ удирдагчид, засгийн газар, олон улсын агент, шинжлэх ухааны академи, байгууллагуудын төлөөлөл бүхий 50 гаруй гишүүдээс бүрдэж байна. (<https://www.broadbandcommission.org/about-us/>)


Уг хорооны үйл ажиллагаа нь НҮБ-ийн Тогтвортой хөгжлийн Дижитал хамтын ажиллагааны зорилтыг хэрэгжүүлэх нэг гол хүч болж өгдөг байна.




Зураг 4. Үүрэн холбоо, хөдөлгөөнт болон суурин өргөн зурвасын интернэтийн үнэ тарифын харьцуулалт, бус нутгаар болон орлогын түвшнээр, **ам.доллараар**



Зураг 5. Үүрэн холбоо, хөдөлгөөнт болон суурин өргөн зурвасын интернэтийн үнэ тарифын харьцуулалт, бүс нутгаар болон орлогын түвшнээр, **PPP \$ буюу Худалдан авах чадварын паритет**



Зураг 6. Үүрэн холбоо, хөдөлгөөнт болон суурин өргөн зурвасын интернэтийн үнэ тарифын харьцуулалт, бүс нутгаар болон орлогын түвшнээр, **GNIPс буюу нэг хүнд ногдох үндэсний нийт орлогод эзлэх хувиар**




© 2022 Mapbox © OpenStreetMap

Суурин өргөн зурвас (5GB cap) - ҮНО-ын нэг хүнд ногдох %

*Зураг 7. Суурин өргөн зурвас сагсны үнэ тарифын харьцуулалт, газрын зурагт, **GNIRS** буюу нэг хүнд ногдох үндэсний нийт орлогод эзлэх хувиар*

Өргөн зурвасын хороо нь өргөн зурвасын хөгжлийг үндэсний болон олон улсын бодлогын түвшинд чиглүүлэх зорилгоор 2011 онд анх 4 зорилт дэвшүүлэн тавьсан бөгөөд 2013 онд 5, 2018 онд 7 болон өргөжүүлжээ. Үүний 2-р зорилт нь **"2025 он гэхэд бага, дунд орлоготой орнуудад нэг хүнд ногдох сарын үндэсний нийт орлогын 2 хувиас бага зардлаар өргөн зурвасын үйлчилгээ авах боломжийг бүрдүүлэх"** гэж тодорхойлсон байдаг. Тус Өргөн зурвасын хорооны 2022 оны тайлангаар зорилтыг хангаж буй улсын тоо өмнөх оноосоо нэмэгдэж, "Хөдөлгөөнт өргөн зурвас, зөвхөн дата" сагсны хувьд нийт 103 улс, харин "Суурин өргөн зурвас" сагсны хувьд нийт 71 улс тус тус зорилтод хүрсэн байна. (<https://www.broadbandcommission.org/advocacy-targets/>)

Монгол Улсын хувьд "Суурин өргөн зурвас" сагсын хувьд 1.87%, "Хөдөлгөөнт өргөн зурвас, зөвхөн дата" сагсны хувьд 1.94% -тайгаар тус зорилтод хүрсэн байна. (Зураг 6, 7, 8)



*Зураг 8. Хөдөлгөөнт өргөн зурвас - зөвхөн дата сагсны үнэ тарифын харьцуулалт, газрын зурагт, **GNIRS** буюу нэг хүнд ногдох үндэсний нийт орлогод эзлэх хувиар*

Ашигласан материал:

1. Handbook for the collection of administrative data on telecommunications/ICT, ITU, 2020
2. ITU Price Data collection methodology, ITU, 2022
3. Policy brief: The Affordability of ICT services 2021, ITU, Alliance for Affordable Internet (A4AI), Measuring Digital Development: Latest insights from ITU, webinar, 5 April 2022
4. ITU ICT price baskets 2008-2021 dataset, ITU, 2022
5. Quick guide to 2025 Advocacy targets of the Broadband Commission, December 2022

Судалгаа, шинжилгээний хэлтэс
Зах зээл үнэ тарифын зохицуулалтын газар
Харилцаа холбооны зохицуулах хороо

2022 он